Тохойн бүлх шөрмөсөнд шунасан хий өвчний үеийн гарын үйл ажиллагааны чадвар алдалтанд уламжлалт бариа заслын эмчилгээний үр дүн

Jin Ai Hua[1], Ba Hu Shan[2] , Wu Da Mu[1], Ta Na[3], З.Болортулга[1]

[1]АШУҮИС, МАУОУС, Уламжлалт эмчилгээний тэнхим
[2]БНХАУ, ӨМӨЗО,Олон Улсын Эмнэлгийн Хороо яс гэмтлийн тасаг
[3]БНХАУ, ӨМӨЗО, Олон Улсын Эмнэлгийн Хороо Таван засал сэргээн засах тасаг
Цахим шуудан: amd22e045@gt.mnums.edu.mn, Утас: 88764257

Түлхүүр үг:

Тохойн атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвсэл
Уламжлалт бариа засал
Тохойн бүлх шөрмөсөнд шунасан хий өвчин

Товч утга:

Үндэслэл:Тохойн үений атгаалын гадна шөрмөсний үрэвсэл бол бугуйн үений нугалах, сунгах хөдөлгөөний давтагдах ачааллын улмаас шөрмөс нь гэмтэж, тохойн гадна хажуугийн булчин шөрмөсний хэсэгт өвдөлттэй, гарын хүч буурч, зорилгот үйлдлийг гүйцэтгэхэд бэрхшээл учруулдаг M77.1-т (ICD-10) олон улсын өвчний ангилалд багтдаг эмгэг юм. Уламжлалт Анагаах Ухаанд мах булчин бүлх шөрмөсөнд шунасан хий өвчин гэдэг нь хий арвидаж, хийн нарийн чийрэг бэлгэ чанарын улмаас бүлх шөрмөсөнд шунаж үүссэн өвчин эмгэг юм. Уг өвчнийг сурвалж зохиолд мод мэт хөших, мөр тахирдах, чирч доголох, бишазэ гэх мэт ангилдаг. Сүүлийн жилд 4.3-5.5%-иар нэмэгдсэн боловч эмчилгээний стандарт тодорхойгүй байна. Үйлчлүүлэгчийн сонирхлын дагуу, мэс заслын бус гаж нөлөө багатай, бариа заслын эмчилгээг өргөн хэрэглэгдсээр ирсэн. Уламжлалт хар архиар барих Монгол Анагаах Ухааны бариа засал нь монгол хүний авьяас ур ухаанаар бий болсон эмчилгээний хамгийн сайн туршлагат, бие махбодод гэмтэл учруулдаггүй, гарын мэдрэмжээр эмчилдэг эмчилгээний өвөрмөц арга юм. **Зорилго:** Тохойн үений булчин бүлх шөрмөсөнд шунасан хий өвчний үеийн гарын үйл ажиллагааны чадвар алдалтанд уламжлалт бариа засал эмчилгээний үзүүлэх нөлөөг судлах. **Арга, аргачлал:** Тус судалгааг АШУҮИС, МАУҮТЭмнэлгийн өдрийн эмчилгээний тасаг, Өвөр Монголын Олон Улсын Эмнэлгийн Хорооны яс гэмтлийн тасагт түшиглэн эмнэл зүйн санамсаргүй хяналтат туршилт зэрэгцүүлсэн судалгааны аргаар 60 үйлчлүүлэгч хамруулан, эмчилгээний бүлэгт хар архиар барих бариа засал, хяналтын бүлэгт хөдөлгөөн заслын эмчилгээг 10 удаа хийж гүйцэтгэв. Гарын үйл ажиллагааны чадвар алдалтыг (Patient-Rated Tennis Elbow Evaluation © MacDermid 2005) үнэлэх асуумж, Оксфордын тохойн онооны (© Isis Innovation Limited, 2008) үнэлгээг ашиглан, гарын атгах хүчийг смарт ухаалаг динамометр (2022) багажаар хэмжиж эмчилгээний үр дүнг дүгнэв. **Үр дүн:** Бидний судалгаанд тохойн үений атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвсэл M77.1-т оношлогдсон бүхий Уламжлалт Анагаах Ухааны мах булчин бүлх шөрмөсөнд шунасан хий өвчин TMA00.24 оношлогдсон бүхий 60 үйлчлүүлэгчийг хамруулахад дундаж нас 49.5±8.5 жил, эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа 33:27 байв. Уламжлалт хар архиар барих бариа засал нь гарын атгах хүчийг смарт ухаалаг динамометр (2022) багажаар хэмжихэд эмчилгээний өмнө эмчилгээний бүлэгт 19.45±5.7 кг, эмчилгээний дараа 28.86±5.64 кг, нэг сарын дараа 31.58±4.93 кг болж сайжирч нэмэгдсэн. Атгаалын гадна шөрмөсний үрэвслийн үеийн зорилтот үйлдлийг гүйцэтгэх үр чадвар алдалтыг PRTEE оноо эмчилгээний өмнө эмчилгээний бүлэгт 31.72±5.79, эмчилгээний дараа 10.20±2.82, нэг сарын дараа 8.08±2.66 оноо (хамгийн сайн оноо 0, хамгийн муу оноо 100) бүхий ач холбогдолтой бууруулан сайжруулж, тохойн ердийн үйл ажиллагааны чадварыг оксфордын тохойн оноогоор эмчилгээний өмнө эмчилгээний бүлэгт 27.71±9.24, эмчилгээний дараа 86.24±4.38, нэг сарын дараа 89.51±5 оноо (хамгийн сайн оноо 100, хамгийн муу оноо 0) бүхий сайжруулсан үр дүнтэй байв. **Дүгнэлт:** 1. Судалгаанд оролцогчдын дундаж нас 47.9±8.0 жил, баруун гарын тохойн атгаалын шөрмөсний үрэвсэл 67% (20) тохиолдож байв. Тохойн атгаалын шөрмөсний үрэвсэлд уламжлалт хар архиар шүршиж барих бариа засал нь статистик ач холбогдол бүхий гарын атгах хүчийг нэмэгдүүлж, тохой бугуйн үйл ажиллагааны чадвар алдалтыг бууруулан сайжруулсан байна. 2. Үйлчлүүлэгчийн өдөр тутмын үйл ажиллагааг дэмжиж, нийгэм-сэтгэл зүйн байдалд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлж байна.

Үндэслэл: Тохойн атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвсэл нь тохойн үений нугалах, тэнийлгэх, давтагдах хөдөлгөөний ачааллын улмаас атгаалын гадна хажуугийн шөрмөс нь гэмтэж, өвдөлтийн шинж тэмдгээр илэрдэг M77.1 (Lateral epicondylitis of elbow ICD-10) оношбүхий эмгэг юм.[1,2] Уламжлалт Анагаах Ухаанд мах булчин бүлх шөрмөсөнд шунасан хий өвчин гэдэг нь хий арвидаж, хийн нарийн чийрэг бэлгэ чанарын улмаас бүлх шөрмөсөнд шунаж үүссэн өвчин эмгэг юм.[3] Уг өвчнийг сурвалж зохиолд мод мэт хөших, мөр тахирдах, чирч доголох, бишазэ гэх мэт ангилдаг. Уламжлалт Анагаах Ухааны өвчний ангилалд TMA00.24 хий бүлх шөрмөсөнд гүйх эмгэгт багтдаг.[4] Хүн амын 3% нь энэ өвчнөөр өвчилдөг, аж үйлдвэрийн ажилчдын 40-50%-д тохиолдсон байна. [5] Мөн газрын теннисийн тамирчинд хүйсийн хамааралгүйгээр тохиолддог болохыг тодруулсан байв.[6] Гар, бугуй шууны хэсэгт өвдөлт дамжин тархаж, тайван үед ч өвдөлт мэдрэгдэж, амьдралын чанарт сөрөг нөлөө үзүүлдэг эмгэг юм.

Тохойн атгаалын гадна хажуугийн шөрмөсийг эмчлэх стандарт эмчилгээ тодорхойгүй, мэс заслын бус эмчилгээ нь эмчилгээний гол суурь хэвээр байна.[7-9] Монгол Анагаах Ухааны хар архиар шүршиж барих эмчилгээний арга нь Монгол хүний амьдралын хэв маяг,ур ухаанаар бий болсон хамгийн сайн туршлагат, хүний биед гэмтэл учруулдаггүй гарын мэдрэмжээр эмчилдэг эмчилгээний өвөрмөц арга юм. Монголчуудын дэлхийн анагаах ухааны хөгжилд оруулсан эмчилгээний аргуудын нэг нь ясны бариа заслын төрөл хар архиар шүршиж барих арга юм.[10] XIII-XIV зууны үеэс “Монголын нууц товчоо”, “Алтан товч” “Юань улсын түүх” зэрэг монголын түүхийн гол сурвалж бичгүүдэд Монголчууд тархины доргилтыг барих, яс барих талаар гарамгай мэргэшсэн төдийгүй Юань улсын үед бариа заслын хэд хэдэн эмнэлэг сургууль байгуулагдан ажиллаж байсан тухай тэмдэглэгдсэн байна.[11] Хүн ард суурьшмал амьдралын хэв маягт шилжсэнээр хөдөлгөөний хомсдол үүсэж, ухаалаг технологийн хэрэглээ ихэссэн нь тохойн үений эмгэгийг нэмэгдүүлэх гол шалтгаан юм. Мэс заслын бус, гаж нөлөө багатай эмчилгээний аргаар эмчлүүлэх үйлчлүүлэгчийн сонирхлын дагуу бариа засал өргөн хэрэглэгдэж ирсэн байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд pubmed нэр хүнд бүхий сайтад тохойн атгаалын шөрмөсний үрэвсэлд бариа заслын эмчилгээний үр дүнг илэрхийлсэн 14 орчим судалгааны ажил нийтлэгдсэн байна. Эдгээр судалгаануудад бариа заслын эмчилгээг сэргээн засах эмчилгээ, кортикостеройд эм тарих эмчилгээний аргуудтай харьцуулан судалж, эмчилгээний үр дүн өндөртэй болохыг тогтоосон байна. Гэвч тохойн атгаалын гадна шөрмөсний үрэвсэлд уламжлалт архиар шүршиж барих эмчилгээний үр дүнг тооцсон судалгааны ажил хараахан хийгдээгүй байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болно.

Зорилго: Тохойн булчин бүлх шөрмөсөнд шунасан хий өвчний үеийн гарын үйл ажиллагааны чадвар алдалтанд уламжлалт бариа засал эмчилгээний үзүүлэх нөлөөг судлах.

Зорилт:

1. Гар тохой, бугуйн үйл ажиллагааны чадвар алдалтанд хар архиар барих уламжлалт бариа заслын үзүүлэх нөлөөг судлах
2. Үйлчлүүлэгчийн өдөр тутмын зорилтот үйл ажиллагаа, нийгэм сэтгэл зүйн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг судлах

Арга, аргачлал: Уг судалгааг АШУҮИС-ийн МАУТЭмнэлэг, Өвөр Монголын Өөртөө засах орны Олон Улсын Монгол Эмнэлгийн Хорооны эмнэлгийн өдрийн эмчилгээний тасагт түшиглэн хийж гүйцэтгэв. Судалгаанд хамрагдах шалгуурыг хангасан таниулах зөвшөөрлийн хуудсаар зөвшөөрсөн 60 үйлчлүүлэгчийг сонгон хамруулсан АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2024 оны 01 сарын 19-ний (№ А/3-01) хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авсан. Компьютерын цахим программ ашиглан, санамсаргүй түүврийн аргаар уламжлалт бариа засал эмчилгээний бүлэг (n=30) , хяналтын бүлэг (n=30) гэсэн 2 бүлэгт хувааж санамсаргүй хяналтат туршилт, судалгааны дан нууцлалын аргаар явуулав. Эмчилгээний бүлэгт хар архиар шүршиж барих бариа засал, хяналтын бүлэгт гарын дасгал хөдөлгөөнийг мэргэжлийн хөдөлгөөн засалчийн хяналтаар 7 хоногт 5 удаа нийт 10 удаа хийж, гэрээр бие дааж хийх зааварчилгааг өгсөн.


Судалгааны үр дүнг тооцохдоо тохойн шөрмөсний үрэвслийн зорилтот үйл ажиллагааны чадвар алдалтыг өөрөө үнэлэх PRTEE (Patient-Rated Tennis Elbow Evaluation © MacDermid 2005) асуумж, Оксфордын тохойн онооны (© Isis Innovation Limited, 2008) асуумж, гарын атгах хүчийг динамометр багажаар хэмжиж, эмчилгээний өмнө, эмчилгээний дараа, эмчилгээ хийгдсэнээс 1сарын дараах үр дүнг харьцуулан дүгнэв.

Үр дүн: Бидний судалгаанд хамрагдсан нийт 60 үйлчлүүлэгчдийн хувьд эмчилгээний бүлэгт эрэгтэй 56% (17), эмэгтэй 44% (13), дундаж нас 47.9±8.0 жил байв. Харин хяналтын бүлэгт эрэгтэй 53% (16), эмэгтэй 47% (14) дундаж нас 48.7±8.5 жил, эмчилгээний бүлэгт зүүн тохой 33% (10), баруун тохой67% (20), хяналтын бүлэгт зүүн тохой 30%(9), баруун тохой 70% (21) тохиолдсон байв. Хоёр бүлгийн хооронд нас хүйсийн ялгаа илрээгүй байна. (p>0.05). (Хүснэгт 1)

Хүснэгт 1. **Үйлчлүүлэгчдийн нас хүйсийн харьцуулсан үр дүн**


Бүлэг	Хүйс		P утга	Дундаж нас (жил)	P утга	Тохойн байрлал		P утга
	Эрэгтэй	Эмэгтэй				Баруун	Зүүн	
Эмчилгээний бүлэг	56% (17)	44% (13)	1	47.9±8.0	0.95	67% (20)	33% (10)	0.69
Хяналтын бүлэг	53% (16)	47% (14)		48.7± 8.5		70% (21)	30% (9)	

Тохойн зорилтот үйл ажиллагааны чадвар алдалтыг өөрөө үнэлсэн үр дүн (PRTEE) Эмчилгээний өмнө эмчилгээний бүлэгт 31.72±5.79, хяналтын бүлэгт 31.33±1.28, эмчилгээний дараа эмчилгээний бүлэгт 10.20±2.82, хяналтын бүлэгт 15.62±7.53, нэг сарын дараа эмчилгээний бүлэгт 8.08±2.66, хяналтын бүлэгт 12.47±5.80 оноо болж буурч, сайжирсан ба эмчилгээний бүлэг, хяналтын бүлэгт тохойн үйл ажиллагааны чадвар алдалт статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. ($p<0.05$) (Зураг 1)




Зураг 1. Тохойн зорилтот үйл ажиллагааны чадвар алдалтыг өөрөө үнэлсэн үр дүн (PRTEE).

Оксфордын тохойн оноогоор (Oxford elbow score OES) ердийн үйл ажиллагааны чадварыг үнэлсэн үр дүн. Оксфордын тохойн оноогоор (OES) тохойн үений ердийн үйл ажиллагааны чадварыг үнэлэхэд эмчилгээний өмнө эмчилгээний бүлэг 27.71±9.24, хяналтын бүлэгт 26.46±6.07, эмчилгээний дараа эмчилгээний бүлэг 86.24±4.38, хяналтын бүлэг 64.75±21.17, нэг сарын дараа эмчилгээний бүлэг 89.51±5.00, хяналтын бүлэг 71.24±18.25 болж тус тус нэмэгдсэн. Эмчилгээний дараа хоёр бүлэгт тохойн ердийн үйл ажиллагааны чадвар статистик ач холбогдолтой нэмэгдсэн байна ($p<0.05$). (Зураг 2)




Зураг 2. Оксфордын тохойн оноогоор (OES) ердийн үйл ажиллагааны чадварыг үнэлсэн үр дүн.

Гарын атгах хүчийг тодорхойлсон хэмжилтийн үр дүн. Гарын атгах хүчийг үнэлэхэд эмчилгээний өмнө хяналтын бүлэгт 20.96±4.66 кг, эмчилгээний бүлэгт 19.45±5.70 кг, эмчилгээний дараа хяналтын бүлэгт 30.84±5.81 кг, эмчилгээний бүлэгт 28.86±5.64 кг, нэг сарын дараа хяналтын бүлэгт 33.06±5.93 кг, эмчилгээний бүлэгт 31.58±4.93 кг болж тус тус нэмэгдсэн. Эмчилгээний дараа болон нэг сарын дараа эмчилгээний бүлэг, хяналтын бүлэгт гарын атгах хүч нь статистик ач холбогдолтой нэмэгдсэн байна ($p<0.05$). (Зураг 3)



Зураг 3. Гарын атгах хүч динамометрийн хэмжилтийн үр дүн.

Оксфордын тохойн оноогоор үнэлэх аргаар үйлчлүүлэгчдийн нийгэм-сэтгэл зүйн амьдралын чанарт үзүүлэх нөлөөг үнэлэхэд эмчилгээний өмнө эмчилгээний бүлэгт 38.13±7.93, хяналтын бүлэг 35.03±4.19, эмчилгээний дараа эмчилгээний бүлэгт 88.08±6.39, хяналтын бүлэг 71.67±17.88, нэг сарын дараа эмчилгээний бүлэг 90.88±5.24, хяналтын бүлэг 76.04±14.96 оноогоор тус тус нэмэгдсэн байлаа. (Зураг 4)



Зураг 4. Оксфордын тохойн оноогоор (OES) амьдралын чанарыг үнэлсэн үр дүн.

Хэлцэмж: Монгол Анагаах Ухааны бариа заслын архи шүршиж барих арга нь хий, цусны эргэлтийг сайжруулж, мэдрэлийг сэргээн идэвхжүүлж, өвдөлттэй хэсгийн өвдөлтийг багасгах, булчин шөрмөсний агшилтыг суллаж тайвшруулах, бодисын солилцоог нэмэгдүүлэх, зөөлөн эдийн эдгэрэлтийг түргэсгэх, эд эсийг нөхөн төлжилтийг дэмжих, өвдөлтийг намдаах, зовуурийг багасгах зорилготой.[12] Архи шүрших нь агаарын даралтаар олон мянган цацраг усан дусал хэлбэрээр биеийн гэмтсэн хэсэгт даралттай хүрэлцсэнээр арьсны гадаргууд хүчтэй цочроох, захын хэсгийн мэдрэлийг сэргээж, хөлсний нүх, хялгасан судсанд гүн нэвтэрч, мэдрэл, шөрмөсийг цочроосноор гэмтэлтэй хэсэгт эс эдийн зөөлөн эдийн эмгэгийн үйл ажиллагааг сэргээн эдгэрэлтийг нэмэгдүүлдэг. Мөн хүний оюун санааны сэрлийг сарниулж, тайвруулах үйлчилгээтэй.[13] Бидний судалгаанд хамрагдсан нийт 60 үйлчлүүлэгчдийн дундаж нас 48.6±8.5 жил баруун тохойн үений шөрмөсний үрэвсэл их тохиолдож байлаа. Энэ нь судлаач Yu mei Zhou (2021) нарын судалгаагаар 796 оролцогчид хамруулсан бөгөөд дундаж нас 44.56-52.5 жил гэсэн үр дүнтэй ойролцоо байна.

Li Wei Yang нарын (Chinese Journalof Rehabilitation, Apr 2021,Vol.36No.4) тохойн үений атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвсэлд үе мөчийг сулруулах хөдөлгөөн дасгал эмчилгээний үр дүнг судалсан судалгаанд дундаж нас 43.4±10.3 жил, зүүн тохой 42.5% (17), баруун тохой 57.5% (23), эрэгтэй 65%(26), эмэгтэй 35%(14) хамрагдаж, эмчилгээний өмнө эмчилгээний бүлэгт PRTEE үйл ажиллагааны оноо 32.9±6.2, гарын атгах хүч 17.82±3.47кг байсан[14,15]. Эмчилгээний дараа үйл ажиллагааны оноо 11.5±5.91, гарын хүч 24.38±4.45кг үр дүн илэрхийлсэн нь бидний судалгааны уламжлалт хар архиар шүрших бариа заслын эмчилгээний үр дүнтэй харьцуулахад дундаж нас 47.9±8.0 жил, зүүн тохой 33% (10) баруун тохой 67% (20) байгаа нь баруун тохойн үений шөрмөсний эмгэг нь харьцангуй элбэг тохиолддог болохыг тодруулав. Мөн үйлчлүүлэгчдийн өдөр тутмын зорилтот үйл ажиллагааны үеийн үйлдлийг гүйцэтгэх ур чадвар алдалтыг PRTEE оноогоор үнэлэхэд эмчилгээний өмнө эмчилгээний бүлэгт 31.72±5.79, эмчилгээний дараа 10.20±2.82, нэг сарын дараа 8.08±2.66 оноо (хамгийн сайн оноо 0, хамгийн муу оноо 100) бүхий бууруулан сайжирсан, гарын атгах хүчийг үнэлэхэд эмчилгээний өмнө эмчилгээний бүлэгт 19.45±5.70 кг, эмчилгээний дараа 28.86± 5.64 кг, нэг сарын дараа 31.58±4.93 кг болж тус тус нэмэгдүүлсэн үр дүн нь уламжлалт хар архин бариа засал эмчилгээ илүү үр дүн өндөртэй болохыг тодруулав.

Бид судалгаандаа үр дүнг улам нарийвчлан үнэлэх зорилгоор үйлчлүүлэгчдийн өдөр тутмын ердийн үйл ажиллагааг оксфордын тохойн оноогоор үнэлэхэд эмчилгээний өмнө эмчилгээний бүлэг 27.71±9.24, эмчилгээний дараа 86.24±4.38, нэг сарын дараа 89.51±5.00 (хамгийн сайн оноо 100, хамгийн муу оноо 0) оноогоор нэмэгдүүлэн сайжруулсан үр дүнтэй байсан нь үйл ажиллагааны алдагдалд уламжлалт хар архин бариа засал үр дүн өндөртэй болохыг харуулж байна. Мөн үйлчлүүлэгчийн нийгэм-сэтгэл зүйн амьдралын чанарт үзүүлэх нөлөөг үнэлэхэд эмчилгээний өмнө эмчилгээний бүлэгт 38.13±7.93, эмчилгээний дараа 88.08±6.39, нэг сарын дараа 90.88±5.24 оноогоор (хамгийн сайн оноо 100, хамгийн муу оноо 0)тус тус нэмэгдүүлсэн байна. Тохойн бүлх шөрмөсөнд шунасан хий өвчний үеийн гарын үйл ажиллагааны чадвар алдалтанд уламжлалт хар архиар шүрших барих бариа засал нь хөдөлгөөн дасгал эмчилгээнээс илүү үр дүнтэй, үйлчлүүлэгчийн өдөр тутмын амьдралын чанарт эерэг нөлөө үзүүлдэг болохыг тогтоов.

Монголын Уламжлалт Анагаах Ухаанд хар архин бариа заслын “архи шүршиж” иллэг хийх аргаар тохойн мах булчин бүлх шөрмөсөнд шунасан хий өвчнийг эмчлэхэд бусад эмчилгээний аргуудтай харьцуулахад аюулгүй, гаж нөлөөгүй, хүндрэлгүй, эмчилгээний үр дүн өндөртэй, эмчлүүлэгчид таатай мэдрэмж төрүүлдэг өвдөлтгүй, зардал багатай тул эмнэл зүйд нэвтрүүлэх боломжтой байна.

Дүгнэлт:

1. Судалгаанд оролцогчдын дундаж нас 47.9±8.0 жил, баруун гарын тохойн атгаалын шөрмөсний үрэвсэл 67% (20) тохиолдож байв.
2. Тохойн атгаалын шөрмөсний үрэвсэлд уламжлалт хар архиар шүршиж барих бариа засал нь статистик ач холбогдол бүхий гарын атгах хүчийг 31.58±4.93кг нэмэгдүүлж, тохой бугуйн үйл ажиллагааны чадвар алдалтыг 8.08±2.66 оноо хүртэл бууруулан сайжруулсан байна.
3. Үйлчлүүлэгчийн өдөр тутмын үйл ажиллагааг дэмжиж, нийгэм-сэтгэл зүйн байдалд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлж байна.

Талархал: Судалгааг хийж гүйцэтгэхэд бүх талаар тусалж дэмжсэн судалгааны ажлын баг болох АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн багш нар, Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлгийн хамт олон, Өвөр Монголын Хөх хотын Олон Улсын Эмнэлгийн хорооны яс, гэмтлийн тасгийн хамт олондоо гүнээ талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Gregory BP, Wysocki RW, Cohen MS. Controversies in surgical management of recalcitrant enthesopathy of the extensor carpi radialis brevis. J Hand Surg. 2016;41(8):856.*
2. *International Statistical Classification of Diseases and Related Health Problems (ICD-10) 2015*
3. *С.Сээсрэгдорж, Ч.Чимэдрагчаа, С.Хишигжаргал, Д.Цэрэндагва, Д.Чулуунчимэг, П. Молор-Эрдэнэ , Монгоын уламжлалт анагаах ухааны овчнийг анагаах увдис 2012.1 50-51*
4. *Монгол улсын эрүүл мэндийн сайдын тушаал,уламжлалт ангаах ухааны өвчний бүлэг оношийн ангиллал код шинэчлэн батлах тухай, 2022-01-28 А155.*
5. *Verhaar JA. Tennis elbow: anatomical, epidemiological and therapeutic aspects. Int Orthop. 1994;18(5):263–267.*
6. *The Mongolian Observer, D.Tserendagva 2015.*
7. *B.K. Coombes, L. Bisset, B. Vicenzino Management of lateral elbow tendinopathy: one size does not Fit all J Orthop Sports Phys Ther, 45 (2015), pp. 938-949*
8. *L. Camp, D.W. Altchek, J.S. Dines, B.C. Werner Epidemiology and disease burden of lateral epicondylitis in the USA: analysis of 85,318 patients HSS J, 14 (2018), pp. 9-14*
9. *T.L. Sanders Jr., H. Maradit Kremers, A.J. Bryan, J.E. Ransom, J. Smith, B.F. Morrey The epidemiology and health care burden of tennis elbow: a population-based study Am J Sports Med, 43 (2015), pp. 1066-1071*
10. *Ruben山aler F, Wiese M, Senge A, et a1. Long—term follow—up of open and endoscopic Hohmann pmcedures I. or lateralepieondylitis. Arthmscopy, 2005, 21(6): 684-6*
11. *Н.Төмөрбаатар. Монголчуудын дорно дахины анагаах ухаанд оруулсан зарим хувь нэмэр. Монголын анагаах ухаан сэтгүүл. 2010 ;1:151-154*
12. *Бао Жиньшань, Бао Жаньхун; Баогийн монгол ясны эмгэг - 5000 гаруй жилийн өмнөх бэлчээрийн соёлын өв залгамжлал, хөгжил; Ази-Номхон далайн уламжлалт анагаах ухаан; 12-р сар. 2018 Vbl. 14УГУЙ. 12*
13. *Бао Жинь Шань, Бао Жань хун; Баогийн монгол ясны эмгэг - 5000 гаруй жилийн өмнөх бэлчээрийн соёлын өв залгамжлал, хөгжил; Ази-Номхон далайн уламжлалт анагаах ухаан; 12-р сар. 2018 Vbl. 14УГУЙ. 12*
14. *Yumei Zhou, Yuebao Guo, Zhuoxin Yang- "Effectiveness of Acupuncture for Lateral Epicondylitis: A Systematic Review and Meta-Analysis of Randomized Controlled Trials*
15. 黎维赕、奚陈平、张伟伟、刘阳、刘晓林．动态关节松动术结合离心训练对肱骨外上髁炎的疗效观察 ． 中国康复， *2024 , 4: 218-210*

Results of traditional Mongolian massage treatment for hand dysfunction in elbow lateral epicondylitis

Jin Ai Hua[1], Ba Hu Shan[2], Wu Da Mu[1], Ta Na[3]. Bolortulga Z[1]

[1]Department of Traditional Therapy, ISMM, MNUMS
[2]Inner Mongolia Autonomous Region International Mongolian Medicine Hospital
[3]Therapy Rehabilitation Department, Inner Mongolia Autonomous Region International Mongolian Medicine Hospital
E-mail: amd22e045@gt.mnums.edu.mn, Tel: +976-88764257

Background: Elbow external grip tendonitis is a condition in which the humeral epicondyle tendon is damaged due to repetitive loading of wrist flexion and extension, causing pain in the external lateral musculotendinous area of the elbow, decreased hand strength, and difficulty in performing purposeful actions (in M77.1 (ICD-10) is a disorder that belongs to the category of international diseases. In traditional medicine, qi disease is a disease caused by qi accumulation and the subtle characteristics of qi. The disease is referred to as stiffness like a tree, stiff shoulders, limping, bishaze, etc. in the literature. It has been increasing by 4.3-5.5% in the last year. Due to this disorder, surgical treatment is performed annually. However, according to the client's interest, bariatric treatment has been widely used, with less side effects of non-surgery. Traditional Mongolian medical bariatric surgery with black alcohol is the best treatment experience created by the talent of the Mongolian people.

Aim: To study the effect of traditional Mongolian massage treatment on hand dysfunction in elbow lateral epicondylitis.

Materials and Methods: The research was based on the day treatment department of, ISMM Hospital, and the bone department of the International Hospital Committee of Inner Mongolia, including 60 patients using the method of randomized controlled clinical trial. . Using the Patient-Rated Tennis Elbow Evaluation (Patient-Rated Tennis Elbow Evaluation © MacDermid 2005) and the Oxford Elbow Score (© Isis Innovation Limited, 2008), hand grip strength was measured with a smart smart dynamometer (2022) to evaluate the treatment results.

Results: In our study, 60 patients with traditional medical arthrosis with a diagnosis of extralateral tendinitis M77.1, average age was 49.5±8.5 years, and the ratio of male to female gender was 33:27. Traditional black alcohol bariatric surgery improved hand grip strength to 19.45±5.70 kg before treatment, 28.86±5.64 kg after treatment, and 31.58±4.93 kg after one month. The PRTEE score in the treatment group was 31.72±5.79 before treatment, 10.20±2.82 after treatment, and 8.08±2.66 after one month (best score 0, worst score 100). The Oxford Elbow score for normal elbow function was 27.71±9.24 before treatment, 86.24±4.38 after treatment, and 89.51±5.00 after one month (best score 100, worst score 0).

Conclusions:

1. The average age of the research participants was 47.9±8.0 years, and 67% (20) of the right elbow tendon injuries occurred.
2. Traditional black alcohol Mongolian massage in patients with aspiration of elbow ligaments has a positive effect on socio-psychological status by increasing hand grip strength, reducing target functional disability, and supporting normal activities.

Keywords: Lateral epicondylitis, Traditional black alcohol mongolian massage treatment, Elbow tendonitis